

**НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. СОНГОХ ДААЛГАВАР****Санамж:**

1. Зохиолын хэсгийг анхааралтай уншиж, ойлгоорой.
2. Асуулт даалгавар бүрийг анхааралтай, дуустал уншиж гүйцэтгээрэй.
3. Эхээс сонгож авсан үг, өгүүлбэрийг эхийн утга санаатай холбож ажиглаарай.
4. Сонгох даалгавраас зөвхөн нэгийг сонгоорой. (Даалгавар бүр 2 оноотой)

**Толгод**

Үдшийн цагт тэнгэр толгодод сарны туяаг шившин оруулна. Гараг оддын аялгуу толгодоос эгшиглэн, нөмөрт нь хоргодом толгод эртний сайхан нөхөд мэт дотно. Энэ бяцхан толгод хэзээ нэгэн цагт уулс болно доо гэж бодном. **Толгод хүүхэд адил өсөж, толгод хүүхэд адил олширч, үдшийн цагаан гэгээнд хөөцөлдөн эрхлэлдэхийг ажиггүй энэ яваа насны учир утга, амьдрахуйн хүслэн тодорно. Тэнгэрээс ах настай уулсын эрх бяцхан ач нар болох энэ толгод салхитай, өвс ногоотой нөхөрлөж, оддод дурлана.**

Намрын үдэш олон бор толгодын дунд даарсан янзага надад бяцхан дүүг минь санагдуулна. Алгаа тоссоор дөхөхөд айсан нүд нь гэм зэмгүйн бэлгэдэл тэр жаахан амьтан холдосхийнэ. Толгод, янзага хоёр ихэр юм шиг санагдана. Хорин жилийн өмнөх ертөнц нүдний өмнө тодорч, эмээ минь толгодын оройд үлгэр шивнэн суух шиг...

Толгод, өвс ногоо, янзага, эмээ, салхи, бид зургаа нэгэн үлгэр болж, сарны туяанд олон толгод амилан, олон цагаан ботго гунганах шиг...

Үлгэр, үнэн хоёр сүлэрч, санаа бодол дээд цэгтээ хүртэл ариусаж, тархи толгойд минь одод бужигнан орж ирж, би өөрөө үгүй, хязгааргүй орон зай, тэнгэр, одод, толгодтой нэгдсэн мэт санагдана. Аажмаар энэ тансаг үлгэр минь тэнгэрт замхарч, бие жихүүцнэ. Бага насны үлгэрийн диваажингаас эргэж ирэхдээ жигтэйхэн эмзэглэж, “Толгодын тоогоор шүлэг бичихсэн” гэж адгана. Толгод бүхэн эх орноо хайрлах сэтгэлийн эрих юм. Сарны цагаан туяа шингэсэн толгоддоо би хорвоогийн жамаар очиж, толгодоос минь гараг оддын аялгуу эгшиглэх тоолон орчлонгийн хязгааргүйд би шингэнэ. Ийнхүү би шүлэглэнэм.

/О.Дашбалбар/

1. Толгодыг эртний сайн нөхөдтэйгөө зүйрлэсний учир юу вэ?
  - A. Хоргодох нөмөртэй байсан учраас
  - B. Бага насандаа тоглон наадаж өссөн учраас
  - C. Толгод амилан, олон цагаан ботго гунганах шиг санагдсан учраас
  - D. Бяцхан дүүг минь санагдуулсан учраас
  - E. Энэ яваа насных нь утга учир тодорсон учраас
2. Эхийн дэвшүүлэн тавьсан асуудал буюу сэдвийг тодорхойлоорой.
 

A. Эх орноо хайрлах тухай	B. Нөхөрлөлийн тухай
C. Амьдралын утга учрын тухай	D. Амьтны үр төлийг хайрлах тухай
E. Хорвоогийн жам ёсны тухай	
3. Эхийн гол санааг илэрхийлсэн тулгуур өгүүлбэрийг олоорой.
  - A. Үлгэр, үнэн хоёр сүлэрч, санаа бодол дээд цэгтээ хүртэл ариусна.
  - B. Энэ бяцхан толгод хэзээ нэгэн цагт уулс болно доо.
  - C. Орчлонгийн хязгааргүйд би шингэнэ.
  - D. Толгод бүхэн эх орноо хайрлах сэтгэлийн эрих юм.
  - E. Аажмаар энэ тансаг үлгэр минь тэнгэрт замхарч, бие жихүүцнэ.
4. Эхийн онцолсон хэсгийн хэв маягийг зөв тодорхойлсныг олоорой.
  - A. Хэрэг явдлыг цагийн дарааллын дагуу өгүүлсэн тул хүүрнэмж
  - B. Энэ яваа насныхаа утга учрыг олон талаар задлан тайлбарласан тул тайлбарламж
  - C. Үйл явдлын шалтгаант холбоог зэрэгцүүлэн үзүүлсэн тул хүүрнэмж, тоочимж хосолсон хэв маяг
  - D. Уул толгодоос амьд явахын шалтгаан нь тодорч буйн учир начрыг баталсан тул эргэцүүлэмж
  - E. Хэрэг явдлыг нэг цагт зэрэгцүүлэн зурагласан тул тоочимж

5. “Сарны цагаан туяа шингэсэн толгоддоо би хорвоогийн жамаар очиж, толгодоос минь гараг оддын аялгуу эгшиглэх тоолон, орчлонгийн хязгааргүйд би шингэнэ.” гэсэн өгүүлбэрийн онцолсон үгтэй ойролцоо утгатай хэлцийг олоорой.  
 А. хорвоогийн шороо хөдөлгөх  
 В. зүрх нь үхэх  
 С. толгойгоо ганзагалах  
 D. тэнгэрт халих  
 E. тэнгэр нь хаях
6. “Толгод хүүхэд адил өсөж, толгод хүүхэд адил олширно.”- өгүүлбэрийн утгын харьцааг тодорхойлоорой.  
 А. Төсөөт утга  
 В. Эсрэг утга  
 С. Ойролцоо утга  
 D. Зүйлчилсэн утга  
 E. Төсөөрхүү утга
7. Цөм өгүүлбэрийг олоорой.  
 А. Хүүхэд адил өснө.  
 В. Аялгуу эгшиглэнэ.  
 С. Өвс ногоотой нөхөрлөнө.  
 D. Цагаан ботго гунганана.  
 E. Тэнгэрт замхарна.
8. “Эмээ минь толгодын оройд үлгэр шивнэн суух шиг...” гэсэн өгүүлбэрт байгаа онцолсон үг ямар гишүүн болох вэ?  
 А. өгүүлэгдэхүүн  
 В. байц  
 С. өгүүлэхүүн  
 D. тусагдахуун  
 E. тодотгол
9. “Намрын үдэш олон бор толгодын дунд даарсан янзага надад бяцхан дүүг минь санагдуулна.” - өгүүлбэрийн хэв шинжийг тодорхойлоорой.  
 А. Угсарсан нийлмэл өгүүлбэр  
 В. Энгийн өгүүлбэр  
 С. Зэрэгцсэн нийлмэл өгүүлбэр  
 D. Харилцан угсарсан нийлмэл өгүүлбэр  
 E. Холимог нийлмэл өгүүлбэр
10. Эхийн өгүүлбэрүүдээс тонгоргон хувиргасныг олоорой.  
 А. Аялгуут бяцхан толгод бүхэн минь эх орноо хайрлах сэтгэлийн эрих юм.  
 В. Намрын үдэш даарсан янзага надад бяцхан дүүг минь санагдуулна.  
 С. Аажмаар энэ тансаг үлгэр минь тэнгэрт замхран, бие жихүүцнэ.  
 D. Алгаа тоссоор дөхөхөд тэр жаахан амьтан холдосхийнэ.  
 E. Ихэр юм шиг санагдана, толгод янзага хоёр.
11. Дараах холбоо үгийг ажиглаад, үндсэн утгаараа байгаа үгийг олоорой.  
 А. айлд шингэх  
 В. тархинд нь шингэтэл хэлэх  
 С. ашиг болж шингэх  
 D. дээлд тос шингэх  
 E. хоол шингэх
12. “Үлгэр, үнэн хоёр сүлэрч, санаа бодол дээд цэгтээ хүртэл ариусна.” гэсэн өгүүлбэрийн онцолсон үйл үгийн утгыг олоорой.  
 А. холилдох  
 В. нийлэх  
 С. сарних  
 D. замхрах  
 E. шингэх
13. Төрөл биш утгатай үгийг олоорой.  
 А. гялай-  
 В. гялгар  
 С. гялдаа  
 D. гялсхий-  
 E. гялалз-

14. “дотно” гэсэн утгад тохирох хэлцийг олоорой.

- A. хуруу дарам
- B. зүү орох зайгүй
- C. хашир хандгай
- D. салхин дэвүүр
- E. гарын аяар

15. Дараах холбоо үгсийн зүй тогтлыг ажиглаад, цэгийн оронд тохирохыг сонгоно уу.

санаа бодол, бяцхан дүү, гэм зэм, жаахан амьтан, .....

- A. нүдний өмнө
- B. цагаан туяа
- C. өвс ногоо
- D. толгод бүхэн
- E. бяцхан толгод

16. “Аажмаар энэ тансаг үлгэр минь тэнгэрт замхарч, бие жихүүцнэ.” гэсэн өгүүлбэрийн онцолсон үгийг тохирох үгээр солин найруулаарай.

- A. Дараа
- B. Яваандаа
- C. Хожим
- D. Цаашид
- E. Чухамдаа

17. “Тэнгэрээс ах настай уулсын эрх бяцхан ач нар болох энэ толгод салхитай, өвс ногоотой нөхөрлөж, одод дурлана.” гэсэн өгүүлбэр дэх онцолсон бүтээврийг солин найруулбал аль нь хамгийн тохиромжтой вэ?

- A. -снөө
- B. -нгөө
- C. -хлөөр
- D. -н
- E. -вөл

18. “Толгодын тоогоор шүлэг бичих сэн” гэж адгана.” гэсэн өгүүлбэрийн онцолсон бүтээврийн утгыг олоорой.

- A. боломжийг батлах
- B. дурсан дурдах
- C. нотлон батлах
- D. барагцаалах
- E. хүсэх

19. Олон тооны дагавар зөв хэрэглэснийг олоорой.

- A. багш нар явах
- B. газар газрын хүмүүс
- C. оюутнууд цуглах
- D. морьд уралдах
- E. олон хүмүүс

20. “эмзэглэ-” хэмээх үгийн зөв бичих дүрмийн тайлбарыг олоорой.

- A. Эгшгээр төгссөн үгэнд үйл үг бүтээх -л дагавар залгахад шууд бичнэ
- B. Эгшигт гийгүүлэгч аль тод хэлэгдэх талдаа заавал эгшигтэй бичигдэнэ.
- C. Заримдаг гийгүүлэгчийн дараа заримдаг гийгүүлэгч ороход заавал эгшигтэй бичигдэнэ.
- D. Эгшигт гийгүүлэгчээр төгссөн үгэнд үйл үг бүтээх –л дагавар залгахад эгшигийг хойно нь бичнэ.
- E. Заримдаг гийгүүлэгчээр төгссөн үгэнд үйл үг бүтээх –л дагавар залгахад эгшигийг өмнө нь бичнэ.

21. Буруу бичсэн бүлэг үгийг олоорой.

- A. биччихийг, туслахаар, төрлөхтнөөр
- B. тулгамдсанаас, шагалзахыг, үзьюү
- C. бузардсанаар, олонхи, хуулчхыг
- D. баримтнаас, хэвлэгдсэнийг, урсжээ
- E. орчихоод, эргэчихбэл, тугаллаа

22. Цэгийн оронд тохирохыг нь сонгоно уу.  
Өгүүлбэрийн доторх тайлбар, тодорхойлолт, нэмэлт ажиглалт зэрэг үг, өгүүлбэрийг ..... бичнэ.
- A. хашилтад
  - B. давхар цэгээр зааглан
  - C. таслалтай зураасаар зааглан
  - D. хаалтад
  - E. зураасаар зааглан
23. Д.Нямсүрэнгийн “Дөрвөн цаг” шүлгийн дүрслэлээс уншаад, улиралтай нь зөв харгалзуулсныг олоорой.
- |   |          |
|---|----------|
| 1. Анирхан ахуйд цэцэг дохих сайхан             | a. өвөл  |
| Аадрын өмнөх байдал сайхан                      |          |
| 2. Тэргэний дугуй чахран чүхран эргэх нь сайхан | b. хавар |
| Тэргэн дороос шувуу нисэх сайхан                |          |
| 3. Навч ганц нэг унах нь сайхан                 | c. зун   |
| Нар толгодын цаанаас гарах сайхан               |          |
| 4. Цөн түрж, гол урсах нь сайхан                | d. намар |
| Цөмөрвөл, би ч бас урсана даа гэж бодох сайхан  |          |
- A. 1b, 2c, 3a, 4d
  - B. 1a, 2d, 3b, 4c
  - C. 1c, 2a, 3d, 4b
  - D. 1b, 2a, 3c, 4d
  - E. 1c, 2b, 3d, 4a
24. “Чингисийн есөн өрлөгтэй өнчин хөвгүүний сэцэлсэн шастир” зохиолд дарааллаараа тохирох хэсгийг олоорой.
- Санасан үгийг маань ..... биш үү
  - Сайн мүү хоёрыг маань ..... биш үү
  - Доторх үгсийг маань ..... биш үү
  - Доор дээр хоёрыг маань ..... биш үү
- A. мэдүүлдэг, илрүүлдэг, ялгадаг, гаргадаг
  - B. илрүүлдэг, мэдүүлдэг, гаргадаг, ялгадаг
  - C. гаргадаг, ялгадаг, илрүүлдэг, мэдүүлдэг
  - D. ялгадаг, гаргадаг, мэдүүлдэг, илрүүлдэг
  - E. мэдүүлдэг, илрүүлдэг, гаргадаг, ялгадаг
25. “Энэхүү Хүннүгийн улс хоёр мянган жилийн тэртээ  
Өмнө Нанхиадыг сүрдүүлж урт хэрмийг цогцлуулсан  
Ромын улсыг хүрч, Европ дахиныг сандруулсан  
Өөрийн дурсгалт зүйлээ Монгол орондоо хоцроосон” гэсэн нь ямар зохиолын дүрслэлт хэсэг вэ?
- A. Дөрвөн цаг /Д.Нямсүрэн/
  - B. Миний монгол /Р.Чойном/
  - C. Монгол хэл /Б.Ринчен/
  - D. Түүхийн шүлэг /Д.Нацагдорж/
  - E. Миний нутаг /Д.Нацагдорж/

26. Монгол бичгийн эхийг уншаад, зөв хөрвүүлснийг олоорой.

- A. Өөхтэй тарган биш боловч эцэнхий морь ч уналга.  
Ураг элгэн биш боловч итгэлтэй нөхөр тустай.
- B. Өгөхдөө тарган биш боловч эцэнхий морь ч уналга.  
Ураг элгэн биш боловч итгэлтэй нөхөр тустай.
- C. Өөхтэй тарган биш боловч эцэнхий морь ч уналга.  
Уурга илхэн биш боловч итгэлтэй нөхөр тустай.
- D. Өөхтэй тарган биш боловч эцэнгэр морь ч уналга.  
Ураг элгэн биш ч итгэлт нөхөр тустай.
- E. Өөхтэй тарган биш ч туранхай морьд ч уналга.  
Ураг элгэн биш ч итгэлтэй нөхөр тустай.

۱. Өөхтэй тарган биш боловч эцэнхий морь ч уналга.  
 ۲. Өгөхдөө тарган биш боловч эцэнхий морь ч уналга.  
 ۳. Өөхтэй тарган биш боловч эцэнхий морь ч уналга.  
 ۴. Өөхтэй тарган биш боловч эцэнгэр морь ч уналга.  
 ۵. Өөхтэй тарган биш ч туранхай морьд ч уналга.

27. Тийн ялгалын нөхцөлийг **буруу** дагуулсан хэсгийг олоорой.

- |       |       |       |       |       |
|-------|-------|-------|-------|-------|
| A.    | B.    | C.    | D.    | E.    |
| ᠮᠤᠯᠤᠯ | ᠮᠤᠯᠤᠯ | ᠮᠤᠯᠤᠯ | ᠮᠤᠯᠤᠯ | ᠮᠤᠯᠤᠯ |

28. Холбох эгшгийн дүрмээр бичсэн үгийг олоорой.

- |       |       |       |       |       |
|-------|-------|-------|-------|-------|
| A.    | B.    | C.    | D.    | E.    |
| ᠮᠤᠯᠤᠯ | ᠮᠤᠯᠤᠯ | ᠮᠤᠯᠤᠯ | ᠮᠤᠯᠤᠯ | ᠮᠤᠯᠤᠯ |

29. “-аасай<sup>4</sup>” нөхцөл залгахад аль нь өвөрмөц бичигдэх вэ?

- |       |       |       |       |       |
|-------|-------|-------|-------|-------|
| A.    | B.    | C.    | D.    | E.    |
| ᠮᠤᠯᠤᠯ | ᠮᠤᠯᠤᠯ | ᠮᠤᠯᠤᠯ | ᠮᠤᠯᠤᠯ | ᠮᠤᠯᠤᠯ |

30. Хатуу дэвсгэрээр төгссөн үгийг олоорой.

- |       |       |       |       |       |
|-------|-------|-------|-------|-------|
| A.    | B.    | C.    | D.    | E.    |
| ᠮᠤᠯᠤᠯ | ᠮᠤᠯᠤᠯ | ᠮᠤᠯᠤᠯ | ᠮᠤᠯᠤᠯ | ᠮᠤᠯᠤᠯ |

31. “Хогийн шүүр” гэсэн холбоо үгийн онцолсон үг аль нь вэ?

- |       |       |       |       |       |
|-------|-------|-------|-------|-------|
| A.    | B.    | C.    | D.    | E.    |
| ᠮᠤᠯᠤᠯ | ᠮᠤᠯᠤᠯ | ᠮᠤᠯᠤᠯ | ᠮᠤᠯᠤᠯ | ᠮᠤᠯᠤᠯ |

32. Буруу бичсэн үгийг олоорой.

A.

ᠬᠢᠷᠪᠦᠷᠲᠠᠭ

B.

ᠬᠢᠷᠪᠦᠷᠲᠠᠭ

C.

ᠬᠢᠷᠪᠦᠷᠲᠠᠭ

D.

ᠬᠢᠷᠪᠦᠷᠲᠠᠭ

E.

ᠬᠢᠷᠪᠦᠷᠲᠠᠭ

33. “хир буртаг” гэсэн үгийг монгол бичгээр зөв бичсэн хэсгийг олоорой.

A.

ᠬᠢᠷ

B.

ᠬᠢᠷ

C.

ᠬᠢᠷ

D.

ᠬᠢᠷ

E.

ᠬᠢᠷ

34. “уурхайчин” гэсэн үгийг монгол бичгээр зөв бичсэн хэсгийг олоорой

A.

ᠤᠦᠷᠬᠠᠢᠴᠢᠨ

B.

ᠤᠦᠷᠬᠠᠢᠴᠢᠨ

C.

ᠤᠦᠷᠬᠠᠢᠴᠢᠨ

D.

ᠤᠦᠷᠬᠠᠢᠴᠢᠨ

E.

ᠤᠦᠷᠬᠠᠢᠴᠢᠨ

35. Бүх үгийг зөв бичсэн хэсгийг олоорой.

A.

ᠬᠢᠷᠪᠦᠷᠲᠠᠭ ᠬᠢᠷᠪᠦᠷᠲᠠᠭ ᠬᠢᠷᠪᠦᠷᠲᠠᠭ  
ᠬᠢᠷᠪᠦᠷᠲᠠᠭ ᠬᠢᠷᠪᠦᠷᠲᠠᠭ ᠬᠢᠷᠪᠦᠷᠲᠠᠭ

B.

ᠬᠢᠷᠪᠦᠷᠲᠠᠭ ᠬᠢᠷᠪᠦᠷᠲᠠᠭ ᠬᠢᠷᠪᠦᠷᠲᠠᠭ  
ᠬᠢᠷᠪᠦᠷᠲᠠᠭ ᠬᠢᠷᠪᠦᠷᠲᠠᠭ ᠬᠢᠷᠪᠦᠷᠲᠠᠭ

C.

ᠬᠢᠷᠪᠦᠷᠲᠠᠭ ᠬᠢᠷᠪᠦᠷᠲᠠᠭ ᠬᠢᠷᠪᠦᠷᠲᠠᠭ  
ᠬᠢᠷᠪᠦᠷᠲᠠᠭ ᠬᠢᠷᠪᠦᠷᠲᠠᠭ ᠬᠢᠷᠪᠦᠷᠲᠠᠭ

D.

ᠬᠢᠷᠪᠦᠷᠲᠠᠭ ᠬᠢᠷᠪᠦᠷᠲᠠᠭ ᠬᠢᠷᠪᠦᠷᠲᠠᠭ  
ᠬᠢᠷᠪᠦᠷᠲᠠᠭ ᠬᠢᠷᠪᠦᠷᠲᠠᠭ ᠬᠢᠷᠪᠦᠷᠲᠠᠭ

E.

ᠬᠢᠷᠪᠦᠷᠲᠠᠭ ᠬᠢᠷᠪᠦᠷᠲᠠᠭ ᠬᠢᠷᠪᠦᠷᠲᠠᠭ  
ᠬᠢᠷᠪᠦᠷᠲᠠᠭ ᠬᠢᠷᠪᠦᠷᠲᠠᠭ ᠬᠢᠷᠪᠦᠷᠲᠠᠭ

**ХОЁРДУГААР ХЭСЭГ. ХАРГАЛЗУУЛАХ ДААЛГАВАР**

**Санамж:**

1. Энэ хэсэг сонгох даалгавар биш тул харгалзааг зөв тогтоож, хариуг бөглөөрэй.
2. Зөв харгалзуулсан хариулт бүр нэг оноотой.

2.1. Хэлцийн утгыг тунгаан, цэгийн оронд тохируулан харгалзуулаарай.

- |   |                               |
|---|-------------------------------|
| a. Нөхрөө орж ирээд байхад ..... яаж байгаа дамшиг вэ?                                  | 1. морь нохой мэт             |
| b. Би та нарт ..... зүтгэн дуртайяа тусална.  | 2. модон өмд өмсчихсөн юм шиг |
| c. Манай Монголчууд хий дэмий гиюүрч, санаа алдан суухыг үзэж чаддаггүй байсан болохоор | 3. нойтон хамуу шиг           |

..... гэж эмээ, өвөө нар загнадаг биз.

- d. Өдгөө хөөмийг уламжлан залгамжлах хүнд үүргийг үүрэх хөөмийчин ..... ховор болжээ.  
e. Гэвч хүүг минь өргөсөн юм гээд манайд ... наалдах хэрэггүй шүү.

4. наймаа алдчихсан хятад шиг  
5. ногоон хурганы арьс, нохойн битүү туурай шиг






2.2. Аман зохиолын жишээг төрөл зүйлтэй нь зөв харгалзуулаарай.

- a. бэлгэ дэмбэрлийн үг 1. Жавартай тэнгэрийн хаяа нэг улаан  
Жаргалтай хатны хацар нэг улаан  
Жалганд ургасан сүхай нэг улаан  
b. мялаалгын үг 2. Сааль нь арвин байг  
Саальчин нь мөнх наслэг.  
c. зүйр цэцэн үг 3. Ган зуднаас хамгаалдаг  
Галт хар үнэгтэй  
Гайхам сайхан Алтай минь  
d. магтаал 4. Найлзуурыг засаж нуруу болгодог  
Нялхыг өсгөж эр болгодог.  
e. ертөнцийн гурав 5. Урд хормой дээр нь унага даага  
Хойд хормой дээр нь хонь хурга гишгэг.

2.3. Зөвийг нь олж сонгоорой.

		1	2	3
a	“-на <sup>4</sup> ” нөхцөлийг шууд залгах үг	тогт + но	арч + на	бууд + на
b	Зөөлний тэмдэг “и” болох үг	сахь + ж	тарь +ж	соль + ж
c	Эр үгэнд “-ы” бичих үг	амьтан	сургамж	хадаг
d	Ялгах эгшиггүй үг	соргог	хэмнэл	чанар
e	Эр үгэнд “-ий” бичих үг	зохиол	цорго	барималч

2.4. Дүрс ялган бичих үгсийг тохирох утгатай нь харгалзуулаарай.

- a.  1. эрж хайх  
b.  2. эрх мэдэл  
c.  3. сампингийн эрх  
d.  4. газар ухах  
e.  5. чангалж эрэх

### СОНСОХ ДААЛГАВАР

Гүйцэтгэх хугацаа: 15 минут

[10 оноо]

Санамж:

- “Магнай хээр” эхийг сонсохын өмнө асуултыг гүйлгэн уншаарай.
- Эхийг анхааралтай сонсоод асуултад хариулаарай.
- Хариултын олон хувилбараас зөвхөн нэгийг сонгож, хариултын хуудсан дээр /36 -40/ зааврын дагуу будаарай.
- Зөв хариулт бүр 2 оноотой.

36. Дараах өгүүлбэрийг гүйцээгээрэй.

Аав: - .... л миний хүү адуундаа яваарай.

- A. Монхор зээрдийн нас шүдийг нь гүйцэхээр
- B. Хээр үрээг уурганд сургахаар
- C. Номхон морьтой болохоороо
- D. Унагааа юүлдэг болохоороо
- E. Ороо догшин морь барьж чаддаг болохоор

37. Аав нь хүүхдүүдээ аашилсны учир юу вэ?

- A. Номхон хээрт хоёул гурвуул сундалсан учраас
- B. Номхон хээрийг наадамд унаж явах гэсэн учраас
- C. Номхон хээрийг урагшаа алхдаггүй гэж унахаасаа дургүйцсэн учраас
- D. Номхон хээрт аргал тэгнэж явахыг харсан учраас
- E. Номхон хээрийг аль байдгаар нь номчилсон учраас

38. “Худлаа даа, их амьтан болно, та нар харж л байгаарай” гэсэн өгүүлбэрээр ямар санааг илэрхийлсэн бэ?

- A. Сайн уургач морь болно гэдэгт итгэлтэй байгаа байдал
- B. Гоёлын сайхан морь болно доо гэж итгэсэн байдал
- C. Номхон морь болно гэдэгт итгэлтэй байгаа байдал
- D. Ороо морь болно доо гэж итгэсэн байдал
- E. Хурдан морь болно гэдэгт итгэлтэй байгаа байдал

39. Магнай хээрт **үл тохирох** шинжийг тодорхойлоорой.

- A. Адууны түрүүнд толгой хаялан дүүхэлздэггүй.
- B. Хөөж гүйцэхгүй морь, уургалж дийлэхгүй адуу үгүй.
- C. Уурга хуйвны сургаар хүлжин давхиж ороолон сортолздоггүй.
- D. Монхор зээрдийг ч барьж чадах ганц морь.
- E. Аавын найр наадамд унадаг гоёлын морь.

40. Эхийн гол санааг илэрхийлэх тулгуур өгүүлбэрийг олоорой.

- A. Сэргэг, соргог, хулан тахь л гэсэн үг.
- B. Унаад явж байхад гандсан тэрлэг ч анзаарагдахааргүй хүлэг л дээ.
- C. Та нар чинь яачихсан монголгүй улс вэ.
- D. Аавын хэлдгээр их амьтан гэдэг ийм байдаг ажээ.
- E. Номхон морь айлд ганц нэг байхад илүүдэхгүй л байх сан даа.